

6. ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт рамын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар цогц мэдлэг, дадлага олгох шаталсан сургалтын тогтолцоо, орчинг бий болгох;

7. Удирдлагын зүгээс төв, орон нутгийн засаг дарга, иргэдийн хуралтай нягт уялдан ажиллаж, нийцүүл байдлаа тогтмол танилцуулан холбогдох шийдвэр, зардлыг гаргуулан ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна гэж үзэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн дэд хурандаа Р. Тэмүрбаатар*

МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ЭРӨНГИЙН ХУУЛИЙГ ӨРЧЛӨХ ЦАГ ӨДИЙН ШААРДЛАГА БАЙГАА

Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль 1992 онд батлагдан гарсанаас хойш 22 жил дагаж мөрдөгдсөн байна. Энэ хууль тухай цаг өдөө шинээр батлагдан гарч нийгэмд шинэ уур амьсгалыг бий болгож байсан бөгөөд төвхэнд өргөө хангалтай биелөлсөн хууль юм.

Гэхдээ энэ хуулийг хэрэглэх явцад зарим зүйл заалтад эргэж анхаармаар эрх зүйн орчинг улам төгөлдөржүүлмээр зүйл цөөнгүй байдаг нь ажиглагдаж байна. Тухайлбал, хуулийн захиргааны хариуцлага хөдөөлгөх эрх бөхий албан тушаалтан гэх 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “шүүгч” гэж тодорхойлон заасан байдаг. Мөн Захиргааны хариуцлага хөдөөлгөх харьяалал тогтоосон 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “шүүгч” энэ хуулийн 21, 23, 24, 251, 30, 301, 302, 303, 304, 306, 31, 32, 33, 34, 342, 36, 37, 40, 41, 42, 45, 48, 531 дүгээр зүйлд заасан зөрчилд шийтгэл ногдуулна гэж заасан¹.

Гэтэл хуулийн 22 дугаар зүйлд “Удаа дараа архидан согтуурч эрүүлжүүлэгдсэн бол 7-30 хөртөл хоног баривчлана” гэх заалтын шийтгэл ногдуулах субъектийн харьяалалыг шүүгчид ногдуулаагүй байхад шүүгч өнөөдрийг хөртөл шийтгэл ногдуулсаар ирсэн байдаг.

Баривчлах шийтгэлийг хөний эрхэнд халдаж хуулийн заалт шаардлагыг хэрэгжүүлж байгаагаараа шүүгч ногдуулах нь зөв боловч хуулинд техникийн шинжтэй гэмээр алдаа гаргасан байдаг.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 22 дугаар зүйлээр арга хэмжээ авагдсан иргэн захиргааны хэргийн шүүхэд хандахад хариуцлагаас чөлөөлөгдөж.

¹ Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль. 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-аар баталсан. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/280>

учирсан хохирлыг нэхэмжлэн авах эрх тусгахээр байгаа нь эндээс харагдаж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл “Танхайрах”, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйл “Танхайрах” Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30² дугаар зүйл “Цагдаагийн алба хаагчын хууль ёсны шаардлага ол биелүүлэх”. Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйл “Түүрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх” зэрэг заалтуудын хоорондын зааг ялгаа тодорхой биш байгаа нь эрх мэдэл хүргүүлж мөнгөтэй хүмүүст хуулийг зөрчлүүлж хэрэглэх бусад иргэнд Эрүүгийн хуулийн заалтыг баримтлан шийдвэрлэн ял ногдуулж байгаа нь хууль хэрэгжүүлэгчид авилгад ортол, нийгэмд шударга ёс алдагдах зэрэг олон сөрөг нэгдэл бий болсоор байна.

Нөгөө талаар Захиргааны хариуцлагын тухай хуулийн ногдуулах торгуулийн хэмжээ Эрүүгийн нөхцөлд нэхээр цаг өөрийн шаардлага хангахааргүй болсон.

Тус хуулиар иргэнийг 50000 төгрөгөөр, албан тушаалтныг 60000 төгрөгөөр, аж ахуй нэгж байгууллагыг 250000 төгрөгөөр торгох торгуулийн дээд хэмжээг заасан нь 22 жилийн өмнө батлан гаргасан байдлаараа одоог хүртэл мөрдөгдөж байгаа нь учир дутагдалтай юм. Энэ хугацаанд мөнгөний имфляцид хэд дахин өөрчлөлт орсон бөгөөд зарим зөрчил гаргасан албан тушаалтан, аж ахуй нэгж байгууллагад энэ хэмжээгээр торгууль ногдуулахад бараг хуулиа зөрчөөд торгуулиа хүлээх нь эдийн засгийн хувьд ашигтай байдал бий болох нөхцөл байдал өөсч байгаа учир энэ хуулийн гүйцэтгэх үрэг дуусгавар болсныг илтгэж байна.

Энэ мэт цөөнгүй зүйлд дээр хуулийн хийдэл гажуудал байгааг эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг боловсруулан УИХ-аар даруй батлуулах нь нийгмийн захиалга бөгөөд цаг өө олсон ажил болж байна гэж үзэж байна.

Эрүүгийн хууль, Захиргааны зөрчлийн тухай хууль нь муу хууль байсан юм биш тухай цаг өдөө олон эрдэмтэн судлаачдын оюун ухаан, ард түмний хүсэлт захиалгаар бий болж бөгөөд тээгдэн нийгэмд үүргээ гүйцэтгэн цаг хугацааны эргэлт хувиралтаар өөрчлөхөөс өөр аргагүй байдалд хүрч байна.

Аливаа хууль эрх зүй тухайн нийгэм цаг өдөө тохирсон, цаг хугацааны эргэлт өөрчлөлтөнд дагаж өөрчлөгдөн хувирч байх нь байгаль, нийгмийн хөгжлийн зүй тогтол юм.

Гэхдээ аливаа зүйл уламжлалгүйгээр ахиж дэвших боломжгүй, энэ үүднээсээ өмнөх хуулийн шалгарсан олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн зүйл заалтын үзэл санааг боловсронгуй болгон хөгжүүлэх нь хамгийн зөв арга гэж үзэж байна.

Хууль эрх зүйг шинэчилж байна гээд бусад нийгэм эдийн засгийн хөгжлийн болоод ёс заншлын асар дор ялгаатай улс орны хуулийг шууд хуулбарлаж нутагшуулах гэж оролдох нь зохисгүй байх талтай.

Дээрх бөгдөөс дүгнэхэд нийгмээр манай улсад эрх зүйн шинэтгэл хэрэгтэй юу. Гүй гэвэл маш их хэрэгтэй тийм ч учраас Зорчлийн тухай болон Гэмт хэргийн тухай хуулийг батлан гаргах тал дээр санал нэгдэж байна.

Нийгмээр манай нийгэмд эрх зүйн шинэтгэлийг эсэргүүцэж, шүүмжилж байгаа нэг хэсэг байгаа, гэхдээ аливаа шинэчлэл эсэргүүцэл, шүүмжлэлгүйгээр шууд зорчлогдөн хувирвал нийгэм харин ч тэр чигээрээ аялдан дагалдагч болж, дарангуйлан ноёрхогч тал бий болсон гэж үзэж болно. Энэ утгаараа эсэргүүцэл, шүүмжлэл байна гэдэг бол Монгол Улсад ардчилал жинхэнэ утгаараа хөгжиж байгаагийн илрэл гэж үзэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дауясааны сонсогч,
цагдаагийн хошууч С.Гантулга*

МОНГОЛЫН БАЙЦААГЧ /МОНГОЛЫН ГЧ-ИЙН ЭРХ ХЭМЖЭЭ ТӨМӨН НИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Монгол Улс 1924 оны 11 сарын 26-ны дор анхдугаар өндсөн хуулиа баталж тусгаар тогтносон бөгөөд дорэн эрхэт, адил тэгш байдлын өндсөн дээр бусад оронтой найрсаг харилцаа тогтооход бэлэн гэдгээ дэлхий дахинаа тунхаглан зарласан. Энэ өндсөн хуульд хөний эрх, эрх чөлөөний талаар тусгахдаа “Тус улсын иргэн угсаа гарал, яс өндэс, нас хөйс, шашин шөтлэг, хөрөнгө чинээ өл харгалзан төрийн өмнө адил тэгш эрхтэй¹” гэж заажээ.

Шинэ өндсөн хууль батлагдсантай холбоотойгоор 1926 оны 04 сарын 16-ны дор БНМАУ-ын Засгийн газрын гишөөдийн 15-р хурал, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай журам”-ыг баталж шүүх байгуулагдсан байна.

Гэмт хэрэг өйлдсэн этгээдийг шүүн таслахаас өмнө “байцаагч төшмөл” гэгч албан тушаалтан гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс биеийн байцаалт, өйлдсэн хэргийн талаар тодруулан тодорхой байцаалтыг авдаг байсан байна. Гэхдээ “байцаагч төшмэд” нь цагдан сэргийлэх байгууллагын ажилтнаас тусдаа өөрийн тусгайлан харьяалсан гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг байсан байна.

Энэ хуулийн заалтаас харахад “байцаагч төшмэд” нь одоогийн мөрдөгч /мөрдөн байцаагч/-ийн ажлыг гүйцэтгэж байсан нь харагдаж байна.

¹ БНМАУ-ын анхдугаар өндсөн хуулийн 3 дугаар зөйлийн 11 дэх хэсэг.